



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ СҮМҮН СОНГУУЛИЙН ХОРООНД

2024.08.05 № 626
таяй _____ ны № _____ т.

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Н.Түвшинжаргалын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай аудит төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021299

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Н.Түвшинжаргал Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцооор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Н.Түвшинжаргалын мөрийн хөтөлбөр
.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Н.Түвшинжаргалд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ



**БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ ИРГЭН НЯМААГИЙН ТҮВШИНЖАРГАЛЫН 2024
ОНЫ АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Нэг. Эрүүл мэнд

- 1.1 Хуванцар савны хэрэглээг багасгах ухуулга сурталчилгаа хийж, бараа зардаг дэлгүүрүүдэд зэвэрдэггүй хөнгөн цагаан сав гэх мэт хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй сав, уут худалдаалулах бодлого баримтална
- 1.2 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэгт хамрагдалтыг өсгөж тогтмолжуулах бодлого баримтална
- 1.3 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
- 1.4 Хүүхэд бие бялдар зөв дадал эзэмшиүүлэх зорилгоор стандартын тогтоолын талбайг сургуулийн орчимд байгуулах бодлого баримтална
- 1.5 Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн эргэлтийг нэмэгдүүлж, үний хөөрөгдлийг хязгаарлах бодлого баримтална.
- 1.6 Эмийн чанар, үнэ аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг цахимаар хянах боломжийг нэмэгдүүлэж health.gov.mn цахим системийн хэрэглээг нэмэгдүүлэх бодлого баримтална

Хоёр. Боловсрол

- 2.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэг, сургуульд сурах орчин бүрдүүлэх бодлого баримтална
- 2.2 Ерөнхий боловсролын агуулга арга зүйд ~~ГУМАНИТАРНЫЙ УЧЕБНИК~~ Монголын түүх, хэл соёл, үндэсний уламжлал, нутгийн зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл сурахын ач тусыг тусган, хүүхдийг хөгжүүлэх амьдралын зөв дадал сургах бодлого баримтална
- 2.3 Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн сургач нэг бүрд шаардлагатай дэмжлэг үзүүлэх, боловсролд тэгш хамруулах бодлого баримтална
- 2.4 Сургуульд байгалийн ухаан, технологийн хичээлийн лабораторийн хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлж, туршилтын талбайг байгуулах бодлого баримтална
- 2.5 Цэцэрлэг, сургуулийн орчны камержуулалтыг нэмэгдүүлж, засварлах ажлыг үргэлжлүүлж хүүхэд аюулгүй, таатай очинд суралцах нөхцөл бүрдүүлэх бодлого баримтална
- 2.6 Спорт заал, дотуур байр, сургуулийн давхар бүрт коридорт хүүхэд ус уух боломжоор хангагдсан ус буцалгагч байршуулах бодлого баримтална
- 2.7 Сурагчдын дотуур байрны зөвлөн эдлэл, ширээ сандал, шкафыг шинэчлэх хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална
- 2.8 Дотуур байрны гал тогоог стандарт болгох бодлого баримтална
- 2.9 Багшийг туршилага судлуулах, шинэ арга барил эзэмшихэд нь зориулж багш солилцооны төсөл хэрэгжүүлэх бодлого баримтална

Гурав. Нийгмийн хамгаалал

- 3.1 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох зорилгын хүрээнд сургалт зохион байгуулах бодлого баримтална

Дөрөв. Эрчим хүч

- 4.1 Сумын төвийн гадаа гэрэлтүүлгийг үе шаттай байгалийн сэргээгдэх эрчим ашиглан солих
- 4.2 Эрчим хүчний хэлбэлзэл ихтэй тогны хүчдэлийн уналт ихтэй газарт трансформатор суурилуулах бодлого баримтална

Тав. Эко аялал жуулчлал

- 5.1 Хануй, цагаан голын рашааны хүрмэнд оруулсан нойлын үйл ажиллагааг гэрээ байгуулан иргэн, аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан хариуцуулан өгөх бодлого баримтална
- 5.2 Хануй, цагаан голын рашаан, Шарга нуурт морь, сарлаг унуулах үйлчилгээг бий болгох
- 5.3 Нүүдлийн аж ахуй өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, малчин өрийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “малчин айлын гэр түрээс” бий болгох бодлого баримтална
- 5.4 Орон нутгийн онцлогийг шингээсэн гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж аялагч, жуулчдад худалдаалах нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримтална
- 5.5 Малын гаралтай бүтээгдэхүүнийг ашиглан Баян-Агт сумын нэрийн бүтээгдэхүүнийг бий болгож, байнгын болон түр үйл ажиллагаа явуулдаг дэлгүүрүүдэд тогтмол худалдаалах нөхцөл бүрдүүлэх бодлого баримтална

Зургаа. МАА, Хөдөө аж ахуй

- 6.1 Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх бодлого баримтална
- 6.2 Баг бүрт өвс тэжээлийн нөөц бий болгох бодлого баримтална
- 6.3 Малын тоо толгойн албан татвараар хийгдэж байгаа ажлуудыг иргэдэд сурталчилна таниулж, тэдний бодит саналд тулгуурласан ажил 8317144798 ҮЙЛЧИЛГЭЭГ ТӨЛӨВЛӨХ 6317144798 ҮЙЛЧИЛГЭЭГ ТӨЛӨВЛӨХ
- 6.4 Тахиа, зөгийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж өргөжүүлэх бодлого баримтална
- 6.5 Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах иргэдийн дэмжиж сумын иргэдийн хэрэгцээг жилийн турш хангах бодлого баримтална
- 6.6 Сүү, сүүн бүтээгдэхүүнийг хэрэглээг сургууль, цэцэрлэгийн үдийн хоолонд нэмэгдүүлэх
- 6.7 Сургуулийн орчинд сурагчдад эрүүл, чанартай, хямд хоол цайгаар үйлчлэх цайны газар бий болгох бодлого баримтална

Долоо. Нийгмийн бусад

- 7.1 Ахуй хүрээний архидалт, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, зочид хүлээн авах зорилгоор зочид буудал, ресторан, паб караоке ажиллуулах иргэн аж ахуй нэгжийг дэмжих
- 7.2 Ахмадын байранд эрүүл хөдөлгөөн хийх тоног төхөөрөмжийг суурилуулах бодлого баримтална
- 7.3 Эрчим хүчний хэмнэлттэй байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлахад байгалийн түгээмэл тархацтай баялаг /элс, хайрга/-аас авах төлбөр хураамжаас чөлөөлөх, эрх зүйн мэдээллийг түгээн дэлгэрүүлэх
- 7.4 Хогийг эх үүсвэр дээр нь ангилах бодлого баримтална
- 7.5 Төрийн албан хаагчдыг ажлын байрандаа ажиллангаа өөрийн албан тушаалын чиглэлээр суралцахыг дэмжих бодлого баримтална